

**БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН УЛСЫН ХОРООНЫ ТӨСВИЙН
ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

2025.06.20

Улаанбаатар хот

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго

Биеийн тамир, спортын улсын хорооны төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 онд байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөний 2025 оны эхний хагас жилийн хэрэгжилтийн үр дүнг үнэлэн, дүгнэлт өгч, зөвлөмж боловсруулан, удирдлагыг үнэн бодит мэдээллээр хангах, төлөвлөсөн зорилтыг бүрэн биелүүлэхэд дэмжлэг үзүүлэх, үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх, хэрэгжилт, хариуцлагыг сайжруулахад хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго оршино.

Хоёр. Хяналт-шинжилгээ, үндэслэл, үнэлгээний арга зүй

Монгол Улсын Засгийн Газрын 2025 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 43 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам”-ын 2.1-д заасны дагуу 2025 оны байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээний 2025 оны эхний хагас жилийн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ хийхдээ Засгийн Газрын 2025 оны “Журам батлах тухай” 43 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам”-ыг удирдлага болгов.

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд туссан 70 арга хэмжээнээс эхний хагас жилийн байдлаар 65 арга хэмжээ тус бүрийн биелэлтийг зорилтот түвшин, үр дүнтэй харьцуулан үнэлсэн. Хяналт-шинжилгээний ажлын явцад зарим тайлан мэдээллийн хэрэгжилтийн байдалд нэмэлт тодруулга авах, асуудал хариуцсан нэгжээс тайлбар авах зэргээр мэдээллийн чанарыг сайжруулах, бататгах ажлыг гүйцэтгэв.

Гурав. Гүйцэтгэлийн төлөвлөгөөний гүйцэтгэлд хийсэн хяналт-шинжилгээний үр дүн.


“Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам”-ын 2.5-д заасны дагуу Биеийн тамир, спортын улсын хорооны Төсвийн төвлөрүүлэн захирагчийн баталсан байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд туссан 8 зорилгын хүрээнд 12 зорилт 70 арга хэмжээнээс 2025 оны эхний хагас жилийн хэрэгжилт тайлагнавал зохих 65 арга хэмжээнд хяналт-шинжилгээ хийхэд 26 арга хэмжээ “бүрэн хангалттай” буюу 85 түүнээс дээш хувь, 19 арга хэмжээ “хангалттай” буюу 70-85 хүртэл хувь, 20 арга хэмжээ “хангалтгүй” буюу 70 хүртэл хувьтай тус тус үнэлэгдэж арга хэмжээний хэрэгжилтийн дундаж **86.3** хувьтай буюу “хангалттай” гэж дүгнэгдлээ.

Хүснэгт 1

Нийт арга хэмжээ	Арга хэмжээний зорилт, хэрэгжилтийн үнэлгээ (хувиар)			Хувь
	Бүрэн хангалттай	Хангалттай	Хангалтгүй	Дундаж хувь
65	100 хүртэл	85 хүртэл	70 хүртэл	86.3
	26	19	20	

Шинэчлэгдэн батлагдсан журмын хүрээнд хяналт-шинжилгээ хийхэд нийт арга хэмжээний 40 хувь нь бүрэн хангалттай буюу 100-85 хувь, 29,3 хувь нь хангалттай буюу 85-70 хувь, 30,7 хувь нь хангалтгүй буюу 70 хүртэл хувьтай үнэлэгдлээ.

График 1



Хүснэгт 2
2025 оны эхний хагас жилийн хэрэгжилтийн үнэлгээний задаргаа

№	Дэс дугаар	Арга хэмжээний	Үйцэтгэлийн хувь
Зорилго 1. Идэвхтэй амьдралын хэв маягтай хүн амыг 3 хувиар нэмэгдүүлнэ.			
Зорилт-1.1. Хүн амын бие бялдрын хөгжлийн түвшнийг хянах сорилын төвийг аймаг, дүүрэг бүрд байгуулж, дата өгөгдөлд дүн шинжилгээ хийх хүчин чадлыг сайжруулах, бие бялдрын хөгжлийн сорилын суурь үзүүлэлт, идэвхтэй хөдөлгөөн, спортын талаарх мэдлэг, хандлага, дадлыг нэмэгдүүлэх.			
1.	1.1.1	Биеийн тамир, спортын салбарын хөгжлийн стратеги төлөвлөгөө боловсруулах.	70%
	1.1.2	Хүн амын бие бялдрын түвшин тогтоох сорилын улсын хэмжээнд авах удирдамжийг баталж, нэгдсэн зохион байгуулалтаар авч, тайлан боловсруулж, дүгнэх	65%
	1.1.3	Хүн амын бие бялдрын хөгжлийн түвшнийг хянах сорилын төвийг аймаг, дүүрэг бүрд байгуулж, дата өгөгдөлд дүн шинжилгээ хийх хүчин чадлыг сайжруулах нэгдсэн мэдээллийн системийн программ хангамжийг хөгжүүлэх	60%
	1.1.4	Хүн амын амьдралын хэв маяг, идэвхтэй хөдөлгөөний мэдлэг хандлага, дадалтай иргэдийн тоог нэмэгдүүлэх зорилгоор "Иргэдийн спортын их наадам"-ыг үе шаттай зохион байгуулах.	100%
	1.1.5	Идэвхтэй хөдөлгөөний дэмжих, хөдөлгөөний хомсдолоос сэргийлэх, бие бялдрыг хөгжүүлэх, ажлын байр, амралт чөлөөт цагаар хийх дасгал хөдөлгөөний талаар олон нийтийн мэдлэг, хандлагыг нэмэгдүүлэх.	60%
	1.1.6	Биеийн тамир, спортоор дамжуулан иргэдийн дунд биеийн тамирын арга хэмжээг цахим болон бусад хэлбэрээр зохион байгуулж идэвхтэй дасгал хөдөлгөөн, спортоор хичээллэгчдийн тоог нэмэгдүүлэх.	70%
	1.1.7	Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачлан хэрэгжүүлж буй "Эрүүл Монгол хүн" үндэсний хөдөлгөөнийг төр, төрийн бус байгууллагуудтай хамтран улс орон даяар зохион байгуулах	80%
	1.1.8	Сумдад ажиллах орон тооны биеийн тамирын арга зүйчдийн мэдлэг боловсролыг дээшлүүлэх сургалт, зөвлөн туслах үйл ажиллагааг зохион байгуулах.	70%
Зорилго 2. Мэргэжлийн спортын хөгжил, эдийн засгийн эргэлтийг дэмжих.			
Зорилт-2.1 Монгол Улсад зохион байгуулах олон улсын тэмцээний тоо, үр ашгийг нэмэгдүүлэх, спортын сургалт дасгалжуулалтын үр дүн сайжруулах, спортын авьяасыг нээн илрүүлж, өрсөлдөхөд чадварыг дээшлүүлэх, допингийн эсрэг үйл ажиллагааг эрчимжүүлэх.			
	2.1.1	Цахим мэдээллийн санд үндэсний шигшээ багийн бус спортын холбоод, наадам, тэмцээн, арга хэмжээний талаарх мэдээлэл байршуулах	100%

2.	2.1.2	Монголын хүүхдийн спортын өвлийн VIII наадам зохион байгуулах, эрхийг гэрээний дагуу шилжүүлэх, зохион байгуулах	100%
	2.1.3	Монголын хүүхдийн спортын зуны VIII наадам зохион байгуулах, эрхийг гэрээний дагуу шилжүүлэх, зохион байгуулах	100%
	2.1.4	Монголын бүх ард түмний спортын XVII наадам зохион байгуулах, эрхийг гэрээний дагуу шилжүүлэх, зохион байгуулах	70%
	2.1.5	Монгол Улсад зохион байгуулагдах олон улс, тив, дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд Засгийн газрын тогтоолын дагуу дэмжлэг үзүүлэх, хяналт тавин спортын холбоодтой хамтран ажиллах	70%
	2.1.6	Үндэсний шигшээ багийн бус спортын төрлийн дэлхий, тивийн наадам, олон улсын тэмцээнд оролцоход дэмжлэг үзүүлэх	90%
	2.1.7	Тусгай олимпын тамирчдыг олон улсын тэмцээн, наадамд оролцоход дэмжлэг үзүүлэх	100%
	2.1.9	Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Хаант Улсын мэргэжлийн Хөлбөмбөгийн Примьер лигийн Фулхэм клубийн сургалтад өсвөрийн тамирчдыг хамруулах	100%
	2.1.10	Дэлхийн допингийн эсрэг байгууллагын татвар, ЮНЕСКО-ийн сайн дурын хандивын зардал гаргах шийдвэр гаргуулах	100%
	2.1.11	ЮНЕСКО-ийн спорт дахь допинг хэрэглэхийг эсрэг конвенц допингийн эсрэг үндэсний дүрмийн хэрэгжилтийг хангуулах талаар Монголын үндэсний допингийн эсрэг байгууллагатай хамтран ажиллах	100%
	Зорилго 3. Үндэсний уламжлалт спортын наадам, нүүдэлчдийн спортын өв, соёл уламжлалыг хөгжүүлэх		
Зорилт 3.1 Нүүдэлчдийн спортын өв, соёл болсон үндэсний уламжлалт спортын наадмын шинжлэх ухааны судалгааны ажлыг өргөжүүлэх, үндэсний спортын төрлийн олон улсын тэмцээн, наадмыг нэмэгдүүлэх, орон нутгийн брэнд арга хэмжээг бий болгох ажлыг эрчимжүүлнэ. (Дотоодын аялал жуулчлалыг дэмжих)			
3.	3.1.1	Үндэсний спортыг сурталчилсан "Нүүдэлчин" фестивалийг зохион байгуулах	70%
	3.1.3	Үндэсний уламжлалт спортын төрлийн олон улсын тэмцээн, наадамд оролцох тамирчдад дэмжлэг үзүүлэх, оролцоог нэмэгдүүлсэн байна.	80%
	3.1.4	Үндэсний уламжлалт спортын төрлийн орон нутгийн брэнд арга хэмжээг бий болгох ажлыг эрчимжүүлэх (Дотоодын аялал жуулчлалыг дэмжих).	70%
Зорилго 4. Өндөр амжилтын спортын хөгжлийг дээшлүүлэх			
Зорилт-4.1 Өвлийн спорт болон үндэсний шигшээ багийн нөөц тамирчдыг бэлтгэх ажлын хүрээнд өсвөр, залуучуудын ангиллын тамирчдын амжилтыг ахиулахад чиглэсэн цогц арга хэмжээ хэрэгжүүлэх.			
4.	4.1.1	Үндэсний шигшээ багт сонгогдсон спортын холбоодтой журмын дагуу гэрээ байгуулан улсын төсвөөс санхүүгийн дэмжлэгийг үзүүлж, дасгалжуулагч, тамирчдыг ажлын байраар ханган үйл ажиллагаанд хяналт тавин ажиллах.	100%
	4.1.2	Олимп, паралимпын наадам, дэлхийн аварга шалгаруулах тэмцээнээс олимпын жин, зайд медаль хүртсэн тамирчин, дасгалжуулагчдад сар бүр мөнгөн урамшуулал олгох.	100%
	4.1.3	Спортын амжилт гаргасан тамирчин, түүний дасгалжуулагчдад нэг удаагийн мөнгөн шагнал олгох.	85%
	4.1.4	Үндэсний шигшээ багуудыг "Милан Кортина-2026" өвлийн олимп, паралимпийн наадам, "Лос Анжелес 2028" олимп, паралимпын наадамд тус тус бэлтгэн оролцуулах, наадамд оролцох эрх авах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх.	100%
	4.1.5	"Лос Анжелес 2028" стратеги төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх.	90%
	4.1.6	Спортын сургалт-дасгалжуулалтын үйл ажиллагаанд спортын дасгалжуулалтын шинжлэх ухааны дэвшилтэд арга зүйг нэвтрүүлэх, судалгаа шинжилгээ хийх болон өсвөр үеийн шигшээ багийн нэгдсэн бэлтгэл цугларалтыг зохион байгуулах /улсын хэмжээнд/.	90%
	4.1.7	Өвөл, зуны Олимп, паралимп, тусгай Олимп, дифлимпын төрлийн шигшээ багуудад дэмжлэг үзүүлэх.	85%
	4.1.9	"Турино 2025" Дэлхийн оюутны өвлийн универсиад наадамд Үндэсний шигшээ багийн бус тамирчдыг оролцоход дэмжлэг үзүүлэх.	100%
	4.1.10	Харбин 2025 Азийн өвлийн спортын IX наадамд оролцоход дэмжлэг үзүүлэх.	100%
	Зорилго 5. Төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах, харьяа байгууллагын удирдлагын үйл ажиллагааг төрийн захиргааны удирдлагаар хангах.		
Зорилт-5.1. Биеийн тамир, спортын салбарын хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, тайлагнах, салбарын хууль, эрх зүйн орчин боловсронгуй болгох, мэргэжил, арга зүйн зөвлөгөө дэмжлэг үзүүлэх			
5.	5.1.1	Биеийн тамир, спортын төрийн захиргааны байгууллагын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, зохион байгуулалтын бүтцийн төсөл боловсруулах.	100%

	5.1.2	Орон нутгийн Биеийн тамир, спортын байгууллагын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, зохион байгуулалтын бүтцийг боловсронгуй болгох, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх.	70%
	5.1.3	Биеийн тамир, спортын тухай хуулийг дагалдан гаргах журам, хөтөлбөр, шалгуур үзүүлэлтийг боловсруулж төслийг хүргүүлнэ.	85%
Зорилт-5.2 Төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах, харьяа байгууллагын удирдлагын үйл ажиллагааг төрийн захиргааны удирдлагаар хангах			
6.	5.2.1	Гүйцэтгэлийн төлөвлөгөө баталж, төлөвлөгөөний биелэлтийг хагас, бүтэн жилээр тайлагнах.	80%
	5.2.2	Салбарын хөгжлийн бодлого, хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн тайланг нэгтгэн тайлагнах.	80%
Зорилт-5.3 Биеийн тамир, спортын салбарын болон хорооны албан хаагчдын сургалтын хөтөлбөр, нийгмийн баталгааны хөтөлбөрийн хүрээнд төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх			
7.	5.3.1	Байгууллагын албан хаагчдын 2025 оны сургалтын төлөвлөгөө батлуулж, хэрэгжилтийг хангах.	80%
	5.3.2	Байгууллагын албан хаагчдын 2025 оны нийгмийн баталгааг хангах төлөвлөгөөг батлуулж, хэрэгжилтийг хангах.	70%
Зорилт-5.4 Бусад хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, тайлагнах, эрх зүйн орчин боловсронгуй болгох, мэргэжил, арга зүйн зөвлөгөө дэмжлэг үзүүлэх			
	5.4.2	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах үйл ажиллагаа зохион байгуулах, тайлагнах	60%
	5.4.3	Хүүхдийн эрхийг хангах талаар үйл ажиллагаа зохион байгуулах, тайлагнах	60%
	5.4.4	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангах, сургалт, үйл ажиллагааг зохион байгуулах	0%
	5.4.5	Иргэдээс төрийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хандаж ирүүлсэн өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэх ажлыг зохион байгуулах, тайлагнах	100%
	5.4.6	Алдар цолтон ахмад настанд төрөөс нэмэгдэл олгох ажлыг зохион байгуулах, тэмдэглэлт өдрүүдэд хүндэтгэл үзүүлэх	80%
	5.4.7	"Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнийг эрчимжүүлэх хүрээн дэх арга хэмжээ, төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах	80%
	5.4.8	Албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг зохион байгуулах, хэрэгжилтийг хангуулах	100%
	5.4.9	Архивын улсын үзлэгт бэлдэх	80%
	5.4.10	Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө (2024-2030)-ний хэрэгжилтийг хангах салбарын үйл ажиллагааны 2025 оны төлөвлөгөөг батлуулж, тайлагнах	80%
	5.4.11	Албан тушаалтны ХАСХОМ, ХАСУМ-ийг бүртгэх, хянах, хадгалах, тайлагнах	100%
	5.4.12	Төрийн болон албаны нууцад хамаарах мэдээллийг боловсруулах, ашиглах, хадгалах үйл ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулах	60%
Зорилго-6.Төсөв, санхүүг оновчтой төлөвлөх, эд хөрөнгө ашиглалт сайжруулах			
Зорилт-6.1 Төсөв, санхүүг оновчтой төлөвлөх, эд хөрөнгө ашиглалт сайжруулах, санхүүгийн үйл ажиллагааны хэрэгжилтийг зохион байгуулах			
	6.1.2	Төсвийг эдийн засгийн ангилал, хөтөлбөр, зориулалт, байгууллага, нэгжээр хуваарилан, сар, улирлын санхүүжилтийн хуваарийг боловсруулж, өөрчлөлт оруулах.	100%
	6.1.3	Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн хязгаар боловсруулах.	100%
	6.1.4	Спортын салбарын болон агентлагийн 2026 оны төсвийн төсөл, 2027-2028 оны төсвийн төсөөллийг нэгтгэн боловсруулж холбогдох тооцоо, судалгаа, тайлбар танилцуулгыг яаманд хүргүүлэх.	85%
	6.1.5	Агентлагийн 2025 оны батлагдсан төсвийн хэрэгжилтийг зохицуулах; удирдлага зохион байгуулалтаар хангах.	70%
	6.1.6	Төсвийн төвлөрүүлэн захирагчийн багцад хамаарах урсгал болон хөрөнгө оруулалтын зарцуулалт үр дүнгийн санхүүгийн нэгтгэсэн тайланг хууль тогтоомжийн дагуу хүлээн авч, хагас бүтэн жилээр нэгтгэн холбогдох байгууллагуудад хүргүүлж, аудит хийлгэн баталгаажуулах.	70%

	6.1.7	Төсвийн шууд захирагчийн багцад хамаарах худалдан авах үйл ажиллагааг зохион байгуулж, гүйцэтгэлийг тайлагнах.	70%
Зорилго-7. Гадаад харилцааг хөгжүүлэх, цахим шилжилтийг эрчимжүүлэх			
Зорилт-7.1 Биеийн тамир, спортын салбар болон агентлагийн гадаад харилцааг хөгжүүлэх, хамтын ажиллагааг өргөжүүлэх			
10.	7.1.1	"Харбин 2025 " Азийн өвлийн X наадам, "Турин 2025 Тусгай олимпын өвлийн наадамд салбарын удирдлагуудыг оролцох арга хэмжээг зохион байгуулах	100%
	7.1.2	Олон Улсын эрдэм шинжилгээний хурал, судалгаа шинжилгээ, сургалтын үйл ажиллагаанд салбарын төлөөллийг оролцуулах	100%
	7.1.3	Өндөр хэмжээний түвшний айлчлалын мөрөөр батлагдсан ажлын төлөвлөгөөг хэрэгжүүлэх	80%
	7.1.4	Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Хаант Улсын мэргэжлийн Хөлбөмбөгийн Примьер лигийн Фулхэм клубтэй хамтарсан сурталчилгаа хөтөлбөр хэрэгжүүлэх	100%
Зорилт-7.2 Салбарын үйл ажиллагааны цахим шилжилтийг эрчимжүүлэх			
11.	7.2.1	Салбарын төрийн цахим үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх	70%
	7.2.2	Салбарын хэмжээнд зохион байгуулагдах спортын наадмын мэдээллийн сан бүрдүүлэх	80%
Зорилго-8 Хяналт-шинжилгээ хийх, үр дүнд нь үнэлгээ өгөх, дотоод аудит хийх, эрсдэлийн удирдлагаар хангах			
Зорилт-8.1 Хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, төсөл, Засгийн газрын тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх, үр дүнд нь үнэлгээ өгөх, дотоод аудит хийх, дотоод хяналт, эрсдэлийн удирдлагаар хангах			
12.	8.1.1	Бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд Хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, дүгнэлт, зөвлөмжөөр хангах, хяналт тавих ажлыг зохион байгуулах	80%
	8.1.2	Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд Хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, дүгнэлт, зөвлөмжөөр хангах, хяналт тавих ажлыг зохион байгуулах	85%
	8.1.3	Захиргааны байгууллагын үйл ажиллагаанд Хяналт шинжилгээ хийж, дүгнэлт, зөвлөмжөөр хангах, хяналт тавих ажлыг зохион байгуулах	85%
	8.1.4	Хяналт шинжилгээ, үнэлгээ дотоод аудитаар чиглэлээр сургалт зохион байгуулах	100%
	8.1.5	Агентлагийн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах, тайлагнах	80%
Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн дүн			86.3%

Дөрөв. Дүгнэлт

Хяналт-шинжилгээ, үнэлгээ нь гүйцэтгэлийн төлөвлөгөөний төлөвлөлт, биелэлтэд үнэлгээ өгөх, хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, шийдвэр нь үр дүнтэй байсан эсэх, гарсан алдаа, дутагдлыг арилгах, дүгнэлт, зөвлөмжийг хэрэгжүүлэхэд чиглэдэг. Биеийн тамир, спортын улсын хорооны Төсвийн төвлөрүүлэн захирагчийн баталсан байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний 2025 оны эхний хагас жилийн хэрэгжилтийн дундаж "Хангалттай" буюу 70-85 хүртэл хувьтай үнэлэгдсэн байна. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний 8 зорилгын хүрээнд 12 зорилт бүхий 65 арга хэмжээнээс 23 арга хэмжээ 100% хэрэгжсэн байна. Мөн хугацаа болоогүй, хэрэгжилт хийгдээгүй 5 арга хэмжээ байна.

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг оновчтой тодорхойлоогүй, шалгуур үзүүлэлт, суурь түвшин, хүрэх түвшинг холбогдох журам, аргачлалын дагуу тодорхой, хэмжигдэхүйц байдлаар томъёолоогүй, хэрэгжих хугацаа тодорхойгүй, төлөвлөлт буруу хийгдсэн дараах арга хэмжээ байна. Үүнд:

Арга хэмжээ 1.1.2 "Хүн амын бие бялдрын түвшин тогтоох сорилын улсын хэмжээнд авах удирдамжийг баталж, нэгдсэн зохион байгуулалтаар авч, тайлан боловсруулж, дүгнэх", арга хэмжээ 2.1.1 "Цахим мэдээллийн санд үндэсний шигшээ багийн бус спортын холбоод, наадам, тэмцээн, арга хэмжээний талаарх мэдээлэл байршуулах", арга хэмжээ 2.1.2 "Монголын хүүхдийн спортын өвлийн VIII наадам зохион байгуулах, эрхийг гэрээний дагуу шилжүүлэх, зохион байгуулах", арга хэмжээ 2.1.3

“Монголын хүүхдийн спортын зуны VIII наадам зохион байгуулах, эрхийг гэрээний дагуу шилжүүлэх, зохион байгуулах”, арга хэмжээ-2.1.4 “Монголын бүх ард түмний спортын XVII наадам зохион байгуулах, эрхийг гэрээний дагуу шилжүүлэх, зохион байгуулах”, арга хэмжээ 2.1.5 “Монгол Улсад зохион байгуулагдах олон улс, тив, дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд Засгийн газрын тогтоолын дагуу дэмжлэг үзүүлэх, хяналт тавин спортын холбоодтой хамтран ажиллах”, арга хэмжээ 2.1.6 “Үндэсний шигшээ багийн бус спортын төрлийн дэлхий, тивийн наадам, олон улсын тэмцээнд оролцоход дэмжлэг үзүүлэх”, арга хэмжээ 2.1.7 “Тусгай олимпын тамирчдыг олон улсын тэмцээн, наадамд оролцоход дэмжлэг үзүүлэх”, арга хэмжээ 2.1.9 “Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Хаант Улсын мэргэжлийн Хөлбөмбөгийн Примьер лигийн Фулхэм клубийн сургалтад өсвөрийн тамирчдыг хамруулах”, арга хэмжээ 3.1.1 “Үндэсний спортыг сурталчилсан “Нүүдэлчин” фестивалийг зохион байгуулах”, арга хэмжээ 3.1.3 “Үндэсний уламжлалт спортын төрлийн олон улсын тэмцээн, наадамд оролцох тамирчдад дэмжлэг үзүүлэх, оролцоог нэмэгдүүлсэн байна”, арга хэмжээ-4.1.7 “Өвөл, зуны Олимп, паралимп, тусгай Олимп, дифлимпын төрлийн шигшээ багуудад дэмжлэг үзүүлэх”.

Тав. Зөвлөмж: Цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ.

Бүх албан хаагчдад:

1. Хэрэгжих хугацаа тодорхойгүй, төлөвлөлт буруу хийгдсэн арга хэмжээ тус бүрийг онцгойлон анхаарч, арга хэмжээг эрчимжүүлэх, хэрэгжилтийг “бүрэн хангалттай” үр дүнд хүргэн ажиллах;

2. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнахдаа зөвлөмжийн биелэлтийг хангах, салбарын хэмжээнд хүрсэн үр дүнг зарцуулсан төсөвтэй уялдуулан нотлох баримттай тайлагнах;

3. Тухайн төлөвлөсөн арга хэмжээ хэрэгжихгүй байх эрсдэлийг урьдчилан тооцоолох, хариу арга хэмжээг шуурхай авч ажиллах, хэрэгжээгүй тохиолдолд шалтгаан нөхцөлийг тодорхой тайлагнаж байх.

Газар, хэлтсийн удирдлагуудад:

1. Хэрэгжилт хангалтгүй үнэлэгдсэн байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг анхаарч ажиллахыг бүх газар, хэлтэст;

2. Зорилтот түвшин, шалгуур үзүүлэлтийн дагуу арга хэмжээг бүрэн хэрэгжүүлж, зохион байгуулалтыг сайжруулах;

3. Гүйцэтгэлийн төлөвлөгөөний шалгуур үзүүлэлт, зорилтот түшиндээ нийцүүлэн, товч тодорхой, үнэн зөв тайлагнаж, хугацаанд нь хэрэгжүүлж, үр дүнг нэмэгдүүлж ажиллах;

4. “Бүрэн хангалттай” буюу 85-с дээш хувьтай үнэлэгдсэн 26 арга хэмжээний үр дүнг цаашид бууруулахгүйгээр чанаржуулж, хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллах шаардлагатай.

ХЯНАЖ БАТАЛГААЖУУЛСАН:
ХШУДАХ-ИЙН ДАРГА

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН:
ХШУДАХ-ИЙН МЭРГЭЖИЛТЭН



Н.БАТСҮХ

Д.УРАНБИЛИГ